



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 141

Номгон

“Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих”  
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 –ийн “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 2/3 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 7 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эмэгтэйчүүдийн эрүүл аюулгүй амьдрах, хөдөлмөр эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, үр хүүхдээ зөв өсгөх, хөгжүүлэх, амьдралын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшин дэх оролцоо, манлайллыг хөгжүүлэх зорилго бүхий “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.



0117094

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын  
29-ний өдрийн 141 дүгээр тогтоолын хавсралт



**“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ”  
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эмэгтэйчүүдийн хөгжлийн өнөөгийн байдал: Баянхонгор аймгийн хүн ам 2016 оны жилийн эцсийн байдлаар 85331 болж, үүнээс 50.6 хувь /43215/ эмэгтэйчүүд, хүн амын 30621 буюу 35.9 хувь 0-17 хүртэл насны хүүхэд байгаагийн 49.4 хувь буюу 15142 охид, 48077 буюу 56.3 хувь хөдөлмөрийн насны иргэд, түүний 48.6 хувь буюу 23354 эмэгтэйчууд, 6633 буюу 7.8 хувь өндөр настны 71.1 хувь буюу 4719 ахмад эмэгтэйчүүд эзэлж байна. Аймгийн хэмжээнд 24821 өрхтэй, 48.9 хувь төв суурин газарт, 51.1 хувь хөдөөд, 27 хувь амьжиргааны төвшин доогуур өрх, нийт өрхийн 4.7 хувь буюу 1999 эмэгтэй өрх толгойлон амьдарч байна.

Хөдөлмөрийн насны 48077 хүний 75.8 буюу 36442 хүн хөдөлмөр эрхэлж байгаагийн 47.1 хувь буюу 17164 эмэгтэйчүүд, ажил хөдөлмөр эрхлээгүй 3762 иргэнээс 2354 буюу 62.6% эмэгтэй, үүнээс бүртгэлтэй ажилгүй иргэд 1515 байгаагийн 859 буюу 56.6% эмэгтэйчүүд байна. Боловсролын салбарт ажиллагсдын 71.3%, төрийн захиргааны байгууллагад ажиллагсдын 40 гаруй хувь, хөдөө аж ахуйн салбарт 49.2 хувь эмэгтэйчүүд, шийдвэр гаргах түвшинд 228 эмэгтэй ажиллаж байгаагийн улс төрийн төвшинд 15.2%, төрийн захиргааны удирдах албан тушаалд 41.3%, төрийн үйлчилгээний салбарт 75%, хууль хяналтын байгууллагад 31.5%, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн 24.3%, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн 22.7% эмэгтэйчүүд эзэлж байна.

Баянхонгор аймгийн нийт эмэгтэйчүүдийн 30.5 хувь төрөх насны эмэгтэйчүүд, 1990 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 42.1 байсан бол 2005 онд 17.1 болж, 2.4 дахин буурч хамгийн бага түвшинд хүрсэн, 2006 оноос нэмэгдэн 2015 онд 25.7, 2016 онд 15.2 болсон ба жилд дунджаар 1960- 2125 эх төрж байгаагийн 19 наснаас доош насны өсвөр насны охидын төрөлт 5.4-5.9 хувийг эзэлж байгаа нь улсын дунджаас 2-3 хувиар өндөр, мэс заслын аргаар 15.7-18.8 хувь төрж байна.

Сүүлийн 3 жилд 8 эх эндэгдсэн, жирэмсэн эмэгтэйчүүдийн 2.7-3.1 хувь цус багадалттай, 10.3-12.3 хувь бэлгийн замын халдварт өвчтэй, нийт төрсөн эхчүүдийн 57.6 хувь нь жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлтэй, амьд төрсөн

хүүхдийн 4.9-5.3 хувь 2500 граммаас доош жинтэй, нийт төрөлтөд ногдох амьгүй төрөлтийн түвшин 7.5- 11.03, төрөлхийн гаж хөгжилтэй 59 хүүхэд төрж, 1000 амьд төрөлтөд 13.1-148.5 үр хөндөлт ногдож байна.

Сүүлийн 10 жилд 0-1 насны 455 хүүхэд эндсэнээс 55 хувь төрөх тойрны үед үүсэх эмгэг, 18 хувь амьсгалын замын өвчин, 14 хувь төрөлхийн гаж хөгжил, 1-5 насны 100 хүүхэд 10 жилд нас барсны 49 хувь осол гэмтэл, 31 хувь амьсгалын замын өвчлөл, 11 хувь төрөлхийн гаж хөгжлөөс болсон байна. Хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүнд хэлбэрийн байнгын асаргаад байдаг 234 хүүхэд байгаагийн 77.3% төрөлхийн, 44.5% уналт таталт, оюун ухаан, сэтгэцийн өөрчлөлттэй. Гэр бүлийн хүчирхийлэл 2014 онд 61, 2015 онд 39 болж 36%-иар буурсан, гэр бүл салалтын тоо 38, 2015 онд 105 болж 63.8%-иар өссөн байна.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага

Баянхонгор аймгийн эмэгтэйчүүд нийгмийн амьдралын бүх салбарт идэвхтэй үүрэг гүйцэтгэж байгаа ч эмэгтэйчүүдийн өмнө тулгамдсан асуудал их байна. Охид, эмэгтэйчүүд эрүүл, саруул байж, гэр бүл төлөвлөлтийн зөв мэдлэгтэй, боловсролтой, ажилтай байснаар тухайн улс орон хөгждөг.

Эмэгтэйчүүдийн боловсрол эзэмшсэн байдал, боловсрол, эрүүл мэндийн салбар дахь ажил эрхлэлт эрэгтэйчүүдийг бодвол илүү үзүүлэлттэй боловч гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн ихэнх нь эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн үнэлэмж бага, хүүхэдтэй болон ахимаг насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал, нийгмийн хамгааллын болон насхилтын асуудал, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо төдийлөн сайн биш байна.

Охид, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн хомсдол, дутагдал, эрүүл мэндийн, нөхөн үржихүйн боловсрол тулгамдсан асуудал болоод байна. Төрөх насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжилтийн ажлыг чанаржуулах ажлыг хийхэд зохион байгуулалт, санхүүжилт шаардлагатай байна. Хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам, хэрэгцээний талаар 580 хүн судалгаанд оролцсоноос 71% эмэгтэй, 29% эрэгтэй, ажил эрхлэлтийн хувьд төрийн байгууллагад 41%, хувийн хэвшилд 19%, хувиараа 15%, ажилгүй 13%, гэртэй хүүхдаа хардаг 0.1 хувийг тус тус эзэлж байна.

Судалгаанд оролцогчид эмэгтэйчүүдийн өмнө хамгийн их тулгамдсан асуудлын талаар эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал гэж 65.5%, хөдөлмөр эрхлэлт 44.6%, хүчирхийлэл 34.6%, өсвөр насны охидын хүмүүжил 33.9%, гэр бүлийн боловсрол 30.3%, эмэгтэйчүүдэд хамгийн их хэрэгцээтэй байгаа 3 асуудлыг

сонгох хүссэн асуулгад 80.1% ажлын байр, 67% эрүүл мэндийн үйлчилгээ, 64.5% санхүүгийн дэмжлэг туслалцаа, сургалтын хэрэгцээний хувьд 34.3% амьдрах ухаан, 31.7, сайн аав, ээж бэлтгэх, 27% төсөл хөтөлбөр бичих аргачлал, 23.6 эмэгтэйчүүдийн ёс зүй, харилцаа, 23.1% өсвөр насын охид хөвгүүдтэй ээжүүдэд зориулсан сургалт хэрэгцээтэй байна гэж үзсэн байна. Мөн гэр бүл төлөвлөлт, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх, ургийн бичиг хөтлөх, эрүүл мэндээ хамгаалах сургалтууд хэрэгтэй байгааг илэрхийлсэн байна.

Жирэмсэн эмэгтэйчүүдийг чанартай, тэжээллэг хоол хүнсээр хангах, охидод чанартай боловсрол эзэмшүүлэх, эмэгтэйчүүдийг чадавхижуулах, ургийг бичгийг айл өрх болгон хөтлөх, жингийн алдагдалтай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх, ажилгүй эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх, охидод бэлгийн боловсрол, ээж болох мэдлэг олгох шаардлагатай байна.

Эмэгтэйчүүдэд амьдрах ухаан, ёс зүй, харилцааны сургалтууд, гэр бүлд сайн аав, ээж болох, гэр бүл төлөвлөлт, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх, ургийн бичиг хөтлөх, эрүүл мэндээ хамгаалах сургалтууд зохион байгуулж, мэдлэг, чадвар олгох, олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан байгуулах, ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжийг дэмжих, урамшуулах хэрэгцээтэй байна.

#### Гурав. Хөтөлбөрийн зорилго, баримтлах зарчим

3.1.Хөтөлбөрийн зорилго: Эмэгтэйчүүдийн эрүүл аюулгүй амьдрах, хөдөлмөр эрхлэх таатай орчинг бүрдүүлэн, тэднийг үр хүүхдээ зөв өсгөх, хөгжүүлэх, амьдралын чанараа сайжруулахад дэмжлэг үзүүлж, шийдвэр гаргах түвшинд дэх оролцоо, манлайллыг хөгжүүлэхэд оршино.

3.2. Баримтлах зарчим: Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлнэ.

3.2.1.Тэгш эрхийн зарчим: эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах;

3.2.2. Ялгavarлан гадуурхахгүй байх зарчим: эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалzan ялгavarлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;

3.2.3. Мэдээлэл хүртээмжтэй байх зарчим: мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах.

3.2.4. Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн бүхий л сайн туршлага, санаачлагыг урамшуулан дэмжих

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, үр дүн, үйл ажиллагаа

Зорилт -1 Эмэгтэйчүүдийн эрүүл аюулгүй амьдрах таатай орчинг бүрдүүлж, хүүхдээ эрүүл өсгөхөд дэмжлэг үзүүлэх

Үр дүн: Охидын төрөлт, жин багадалтай хүүхдийн болон төрөлхийн гаж төрөл, жирэмсэн эхийн цус багадалт, хүндэрэл, үр хөндөлт 2017 оныхаас хөтөлбөр хэрэгжих хугацаанд 1-3 хувиар буурсан байна.

Зорилт 1-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа:

1.1 Жирэмсэн эмэгтэйчүүдийг эрүүл, тэжээллэг хоол, хүнсээр хангах “Эрүүл гэр бүл-Эрүүл эх-Эрүүл хүүхэд” төсөлт хэрэгжүүлэх

1.2. Ахлах ангийн охид, хөвгүүдэд “Ирээдүйн ээж, аав” төсөлт арга хэмжээг сургагч багш нар бэлтгэж хэрэгжүүлэх.

1.3. Өрх толгойлсон, олон хүүхэдтэй эхчүүдэд хүүхдээ эрүүл өсгөх “Миний хүүхэд” төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх

1.4. Өсвөр насын охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэгийг жил бүр зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах

1.5. Малчин эмэгтэйчүүд бага насын хүүхдээ өсгөх, төлөвшүүлэх, хүмүүжүүлэхэд зориулсан сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өргөжүүлэх

1.6. Дотуур байрыг хүүхдэд ээлтэй болгох “Миний байр-Миний гэр” арга хэмжээг хэрэгжүүлэх

1.7. Бага насын хүүхэдтэй ээжүүдэд зориулсан онлайн сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх

1.8. Төрийн байгууллагуудад чиглэсэн “Эрүүл, аз жаргалтай гэр бүл” төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх

1.9. Жирэмсэн болон 0-2 насын хүүхдээ харагч залуу эхчүүдэд хүүхдийн хоол тэжээлийн дутагдлаас сэргийлэх, хүүхдийн насанд тохирсон хоол бэлтгэх “Гал голомт” төсөлт арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

1.10 Зорилтот өрх гэр бүлийн гишүүдийг хөгжүүлэх “Хөршийн холбоо” арга хэмжээг хэрэгжүүлэх

Зорилт-2 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлого, амьжиргааг сайжруулж, ядуурлаас гаргах

Үр дүн: Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн эдийн засгийг сайжруулан, дундаж орлоготой өрхийн түвшинг жил бүр 1-2 хувиар нэмэгдүүлсэн байна.

Зорилт 2-ын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа:

2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрүүдээр ажилгүй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

2.2. Ажилгүй хөдөлмөр эрхлэх хүсэл, зорилготой эмэгтэйчүүдийг ажил мэргэжлийн чиг баримжаа, бизнес инкубаторийн үйлчилгээгээр чадваржуулан, тэдний сонголтоор бүлэг, нөхөрлөл, хоршооны хэлбэрт оруулан, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, зээлээр дэмжиж “Ажилсаг төв”-д өрөө гарган өгч, ажилтай, орлоготой болгох

2.3. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжиж төсөл, хөтөлбөрт хамруулах

2.4. Мал аж ахуйгаа эрхлэн, малаа сааж сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч малчин эмэгтэйчүүдийн алдаршуулах, урамшуулах “Уламжлалт сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч” аймгийн болзолт журам боловсруулж хэрэгжүүлэх

2.5. Төв суурин газар ажил, орлогогүй байгаа хөдөлмөрийн насын эмэгтэйчүүдийг гэр бүлээр нь аймаг, сумын аварга малчин өрхүүдтэй гэрээ байгуулан “Мал дагавал, ам тосдоно” төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх

2.6. Олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хүүхдүүдийг зуны амралтаар нь олон малтай малчидтай гэрээ байгуулан уламжлалт мал аж ахуй эрхлэх чадварт сургах “Хүн болох багаасаа” төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх

2.7. Өрх толгойлсон, олон хүүхэдтэй, амьжиргааны түвшин доогуур байгаа эмэгтэйчүүдийг эн тэргүүнд анхааран эмэгтэйчүүдэд зориулсан ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг дэмжих

2.8. 40-өөс дээш насын эмэгтэйчүүдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллага, малчид, иргэдийг урамшуулах, алдаршуулах

2.9. “Сайн эхнэр” сэдэвт амьдрах ухааны 12 модуль сургалтыг эмэгтэйчүүдэд зохион байгуулах 2-3 сургагч багшийг сум бүрт бэлтгэн чадваржуулж, орон нутгийн залуу эмэгтэйчүүдийг хөгжүүлэх

2.10. Олон нийтийн оролцоо, өөрийгөө хөгжүүлсэн, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад хамрагдаж чадваржсан эмэгтэйчүүдэд буцалтгүй дэмжлэг олгох, хөнгөлөлттэй зээлд хамруулах “Сайн үйлийн эзэн” журам боловсруулан хэрэгжүүлэх

2.11. Аймаг, сум, иргэд, гэр бүлийнхээ хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулсан, ажил үйлсээрээ манлайлагч, үр хүүхдээ сайхан өсгөсөн, бусдын төлөө сэтгэлээсээ ажилласан ахмад эмэгтэйчүүдийн ажлын туршлагыг залуу үеийнхэнд өвлүүлэх “Амжилтын эзэн” төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх

2.12. Бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн үйлдвэрлэлийг өргөтгөхөд тоног төхөөрөмж, байр, зээлийн бодлогоор дэмжиж, шат дамжлагатай томоохон үйлдвэрлэгч болгох /гутал, оёдол, хүнсний г.м/

2.13. Үйлдвэрлэл эрхлэгч болон үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой эмэгтэйчүүдийг дотоод, гадаадын үйлдвэрлэлтэй танилцах аялал, үзэсгэлэн худалдаанд оролцуулах, мэдлэг, туршлагатай болгох, борлуулалтыг дэмжих бодлого хэрэгжүүлэх

2.14. Хувиараа үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнесээ эхэл”, “Бизнесээ хөгжүүл” хуримтлалын бүлэг үүсгэх сургалтаараа чадваржуулан, бизнесийн төлөвлөгөөтэйгээр үйлдвэрлэлээ хөгжүүлдэг мэдлэг олгох

2.15. Олон малтай малчидтай гэрээ байгуулан, мал сааж, цагаан идээ борлуулах үйлдвэрлэл явуулах хүсэлтэй суурин газрын ажилгүй эмэгтэйчүүдийг түр ажлын байраар хангах

2.16. Ажилгүй эмэгтэйчүүдийг “Илгээлтийн эзэн” хөтөлбөрт хамруулж, байнгын ажилтай болгох

Зорилт -3 Охид, эмэгтэйчүүдийг чадваржуулах, хөгжүүлэх, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Үр дүн: Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоо дээшилж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийг тоог 2016 оноос 2 дахин, олон нийтийг чадваржуулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил үйлчилгээний тоо жил бүр өссөн байна.

Зорилт 3-ын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

3.1. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшний судалгаа, мэдээллийн сантай болж, бичиг үсгийн боловсролгүй охид, эмэгтэйчүүдийг насан туршийн боловсролын байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран бичиг үсэгтэй болгох

3.2. Охид, эмэгтэйчүүдийн сонирхол хобби дээр тулгуурласан клубуудыг байгуулах, дэмжих, тэднийг хөгжүүлэх

3.3. Өсвөр насны охид, эмэгтэйчүүдийг биеэ үнэлэх, эрх зөрчигдэх, дарамт шахалт, хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нөлөөлөл, соён гэгээрүүлэх ажлыг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх

3.4. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчилгээ үзүүлэх, сургалт хийх, зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлэх

3.5. Аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилд ажилладаг эмэгтэйчүүдийг “Хөгжлийн төлөө эмэгтэйчүүдийн манлайлал” багц сургалтанд хамруулж, дөрвөн /“Манлайлал ба эмэгтэйчүүд”, “Хүний эрх, засаглал”, “Тогтвортой хөгжил”, “Сонгууль ба эмэгтэйчүүд”/ үндсэн модулийг хэрэгжүүлэх

3.6. Төр, олон нийтийн байгууллагуудад жөндэрийн зохистой харьцааг бий болгон аливаа удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн ажиллах боломжийг бүрдүүлэх

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замууд

5.1. Хөтөлбөр боловсруулсан ажлын хэсэг хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.

5.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулж бүх сумдад хүргүүлнэ.

5.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрийг төлөвлөн эзэнжүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр аймгийн Засаг даргын захирамжаар үүрэгжүүлж, хяналт тавих ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргад үүрэг болгоно.

5.4. Хөтөлбөрийн төсөл арга хэмжээнүүдийг тухай бүр төсөл боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлж хэрэгжүүлнэ. Төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн тайланг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж, үнэлүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	X/нэгж	2016 оны түвшин	2017	2018	2019	2020	2021
1	Хөдөлмөрийн насны хүн амд хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүд түвшин	хувь	37.9	38	38.3	38.5	38.8	39.0
2	Өсвөр насны охидын төрөлт	хувь	7.5	7.3	7.2	7.0	6.8	6.6
3	2500 граммаас доош жинтэй төрсөн хүүхэд	хувь	5.5	5.4	5.3	5.2	5.0	4.8
4	Амьгүй төрөлтийн түвшин /нийт төрөлтөд оогдох/	хувь	6.1	6.0	5.9	5.8	5.7	5.6
5	Жирэмсэн эхийн цус багадалт	хувь	3.1	3.0	3.0	3.0	2.9	2.9
6	Жирэмсэн ий, төрөх, төрсний дараах хүндрэл	жирэмсэ н үеийн	хувь	62.1	61.0	60.0	59.0	58.0
		төрөх үеийн	хувь	36.1	35.1	35.1	34.9	34.0
		төрсний дараах	хувь	1.8	1.3	1.0.	1.0	1.0

7	Үр хөндөлт /1000 амьд төрөлтөд/	хувь	148.5	140.5	135	130	125	120
8	Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлт	хувь	101.7	46.8	0	0	0	0
9	Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүд	хувь						
10	Дундаж орлоготой өрх	хувь	Тоо байхгүй	40.0	41.0	42.0	43.0	45.0
11	Олон нийтийн арга хэмжээнд оролцсон эмэгтэйчүүд	тоо	Бүртгэлгүй тоо байхгүй	9500	10500	11000	12000	13000

Долоо. Хэрэгжилтийн үнэлгээний арга хэлбэр, үе шат

7.1 Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд дэх үйл ажиллагааг жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

7.1.1 1-р үе шат буюу 2017-2019 он /2019 оны 3-р сард үнэлгээ хийх/

7.1.2 2-р үе шат буюу 2019-2021 он /2021 оны 1-р сард үнэлгээ хийх/

7.1.3 Явцын үнэлгээ буюу мониторингийг 2 жил тутамд зохион байгуулж, эцсийн үнэлгээг 2021 онд зохион байгуулж, дүнг мэдээлж ажиллана.

7.2 Төлөвлөгөөний биелэлтийн явцыг аймгийн ажлын хэсэг аймгийн Засаг дарга, Нийгмийн бодлогын хэлтсийн даргад мэдээлж, тайлagna ба Нийгмийн бодлогын хэлтсийн тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар иргэдэд мэдээлэх ажлыг хариуцан зохион байгуулна. Биелэлтийн явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлж ажиллана.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын удирдлага, зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалт, аймаг, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл бусад төсөл хөтөлбөр, төсвийн санхүүжилттэй нягт уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцан, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсрол соёл урлагын газар, Эрүүл мэндийн газар, Насан туршийн боловсролын алба, “Гал голомт” ТББ, сумдын Засаг даргын Тамгын газар, сумдын Нийгмийн түншлэлийн багууд, хөтөлбөр, төслийн газруудын оролцоотойгоор хамтран хэрэгжүүлнэ.

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт

9.1 Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- 9.1.1 Улсын төсөв
- 9.1.2 Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө
- 9.1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- 9.1.4 Сум хөгжүүлэх сан
- 9.1.5 Орон нутгийн хөгжлийг дэмжих сан
- 9.1.6 ЖДҮ -ийг хөгжүүлэх сангийн хүрээнд хуваарилсан хөрөнгө
- 9.1.7 Дотоод, гадаадын хандивлагч байгууллагуудын зээл тусlamж, төсөл
- 9.1.8 Аж ахуй нэгж байгууллага, иргэдийн хандив, зээл тусlamж  
Арав. Хяналт, үнэлгээ

10.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт, үнэлгээ хийх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг эрхлэн гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ хийх ажлын хэсэгт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, Эмэгтэйчүүдийн холбоо, иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байна.

10.2. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээний ажлын зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн шалгуур үзүүлэлт, зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамжийг нэгтгэн дүгнэх, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулсан хөрөнгө хүндээ хэрхэн хүрч зохих дэмжлэг болж чадсаныг судалгаа, шинжилгээ, олон нийтийн оролцооны аргаар тогтоох, цаг үеийн байдалтай холбогдуулан хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах, зөвлөмж, санал дүгнэлт гаргана.

Арван нэг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл

- 11.1 Монгол Улсын Үндсэн хууль;
- 11.2 Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030
- 11.3 Эрүүл мэндийн тухай хууль
- 11.4 Гэр бүлийн тухай хууль
- 11.5 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- 11.6 Хүүхдийн эрхийн тухай хууль
- 11.7 Хүүхэд хамгааллын тухай хууль
- 11.8 Хөдөлмөрийн тухай хууль;
- 11.9 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;
- 11.10 Хуульд нийцүүлэн гаргасан Засгийн газар, яам, тусгай газрын журам, тогтоолууд, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, бусад шийдвэрүүд;

## Арван хоёр. Эмэгтэйчүүдийн үзүүлэлт

Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Нийт хүн ам	хүн	82439	81106	82884	83603	85331
Үүнээс эмэгтэйчүүд	хүн					43215
Хөдөлмөрийн насны нийт хүн ам	хүн	51776	44870	49989	45493	52942
Үүнээс Эмэгтэйчүүд	хүн	25920	25558	25392	25060	22523
Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүн ам	хүн	49656	48038	48305	48492	49741
Эдийн засгийн идэвхитэй хүн ам	хүн	37658	39148	38421	40588	40853
ААНБ-д ажиллагсад	хүн	35950	36290	37776	38980	39338
Үүнээс эмэгтэйчүүд	хүн	17849	18022	18698	19054	18866
Нийт ажиллагсадад эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн эзлэх хувь	хувь	49.65	49.66	49.50	48.88	47.96
Хөдөлмөрийн чадвартай хүн амд хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь	хувь	35.95	37.52	38.71	39.29	37.93
Эдийн засгийн идэвхтэй хүн амд хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн эзлэх хувь	хувь	47.40	46.04	48.67	46.94	46.18
Бүртгэлтэй ажилгуйчүүд	хүн	1708	2858	2244	2680	1515
Үүнээс эмэгтэйчүүд	хүн	897	1521	1010	914	859
малчид	хүн			20962	21062	22001
Үүнээс эмэгтэйчүүд	хүн			9926	9894	10286
Төрсөн эх	хүн	2119	2308	2174	2125	1960
Өсвөр насны төрөлт	аймаг	хувь	7.03	7.7	7.4	8.09
	улс	хувь	5.9	5.7	5.5	5.4
Төрөлхийн гаж хөгжил	хүн	8	11	23	14	22
Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлт	аймаг	хувь	188,3	0	137.4	46.8
	улс	хувь	50.8	42.6	30.6	26
Эхийн эндэгдэл	тоо	4	0	3	1	2
Жирэмсний хяналтад орсон эх	Эрт үе	хувь				80.3
	4-6 сар	хувь				18.3
	хожуу	хувь				1.2
Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүд	аймаг	хувь	1.5	3.8	3.1	2.7
	улс	хувь	6.5	4.8	4.3	
Үр хөндөлт 1000 амьд төрөлт	аймаг	хувь	82,9	67.4	61.8	13.1
	улс	хувь	247	159.9	222.1	
Гэрийн төрөлт	хувь	0,23	0,35	0,36	0,42	
Мэс заслын аргаар төрсөн эх	хувь	15.1	15.5	15.7	18.8	22.2
Эмэгтэйчүүдийн хүндэрэл	жирэмсэн үеийн	хувь				52.6
	төрөх үеийн	хувь				38.5
	төрсний дараах	хувь				7.02
0-1 насны хүүхдийн эндэгдэл	аймаг	хувь	14.1	18.1	15.1	14.1
	улс	хувь	15.3	14.6	15.3	15.3
Перинаталь эндэгдэл	аймаг	хувь	13.1	15.8	17.3	14.1
	улс	хувь	14.0	14.4	14.5	14.6
Гэр бүл салалт		50	47	41	61	57